



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар

6/19

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 45 дугаар зүйлийн 45.4, 48 дугаар зүйлийн 48.1 дахв заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Наранмандал Энтерпрайзес” ХХК, “Эрдэнэ Монгол” ХХК, “Сэкер ресурс монголиа” ХХК болон бусад уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагын хамтран ажиллах гэрээнд тусгах санал нөхцөлийг хэлэлцэх, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батсуурь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын зөвлөх

Гишүүд:

У.Балжинням Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

М.Мөнгөнцэцэг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Т.Хишигбаатар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

З.Шарав Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Б.Соронзонбаатар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

А.Лхагвадорж Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Л.Чинзориг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Т.Бат-Очир Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Т.Бямбадорж Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

П.Дашзэвэг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Нарийн бичгийн дарга:

D;2025on;togtool2025

642501032

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ичинхорлоо

2.Ажлын хэсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй гэрээний нөхцөлийг хэлэлцэх, санал дүгнэлт боловсруулах чиглэлээр бүх талын дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3.Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

3.1. Геологи, уул уурхайн салбарын эрдэмтэн судлаачид, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа мэрэгжлийн төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, экспертүүдтэй хамтран ажилласугай.

3.2. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээ, мэдээллүүдийг нээлттэй, ил тод мэдээлсүгэй.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй нутгийн захиргааны байгууллагын байгуулах гэрээнд тусгах санал, нөхцөлийг судлан санал дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулсугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ